



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/107

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргээ чанаржуулан, ашиг шимийг нэмэгдүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, мал аж ахуйг эрчимжүүлэх, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар амжилт гаргаж “Аймгийн аварга малчин өрх”, “Аймгийн аварга саальчин”, “Аймгийн аварга фермер”, “Аймгийн аварга тариаланч”, “Аймгийн аварга тариаланч хамт олон”, “Аймгийн тэргүүний хоршоо”-оор шалгарсан малчид, тариаланчдад шагналыг гардуулж, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Малчид, тариаланчдад шагналыг гардуулж, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3. Шагнал гардуулж, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд шаардагдах нийт 5,510,000 (таван сая таван зуун арван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0170

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 23 дугаар
сарын 01-ны өдрийн 1107 дүгээр
захирамжийн хавсралт



АВАРГА МАЛЧИД, ТАРИАЛАНЧДАД ШАГНАЛЫГ ГАРДУУЛЖ, ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

Д/д	Ажил үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Телевизийн нэвтрүүлгийн зардал	тоо	1	1979800	1979800
2	Зураг	ш	89	20000	1780000
3	Тавгын идээ				1200200
4	Хөтлөгчийн хөлс	хүн	1	100000	100000
5	Морин хуурч, дуучдын хөлс	хүн	3	150000	450000
Нийт					5510000

-оОо-